



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/369

Булган сум

Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрлийн тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1, 8.1 дүгээр зүйлийн 12 дугаар хэсгийн 12.13 дахь хэсэг, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4, 15 дугаар зүйлийн 15.1, 15.3, 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/04 дүгээр тушаалаар батлагдсан “Согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтын журам”, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/419 дүгээр тушаалаар батлагдсан “Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл авах үйлчилгээний ангилал, тавигдах шаардлага”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох цэгийн нэрийг хавсралтаар баталсугай.


2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/482 дугаар захирамжийн Хутаг-Өндөр сумын Б.Эрдэнэсүвд захиралтай “Түмэн сувдны хишиг” ХХК-ийн Хутаг-Өндөр сум 1-р баг, Гуртын 1-138 тоот хаягт байршилтай “Маргад” хүнсний дэлгүүрийн согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийг хүчингүйд тооцсугай.

3. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.1, 35.2.2-т заасан тэмдэгтийн хураамжийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхийг сумын Засаг дарга, Татварын газар (Д.Лхагвасүрэн), Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Гантулга)-д тус тус даалгасугай.

4. Дээрх цэгүүдийн үйл ажиллагаанд холбогдох хууль, журам, стандартуудын хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Цагдаагийн хурандаа Б.Эрдэнэбилэг), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Н.Пүрэвсайхан), Стандарт, хэмжил зүйн хэлтэс (Д.Алтаншагай), сумын Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2026 оны
 05 дугаар сарын 19-ны/ний өдрийн
 А.369 дугаар захирамжийн хавсралт



**“СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ
 ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ” ЭЗЭМШИХ ЦЭГИЙН НЭРС**

д/д	Сумын нэр	Аж ахуйн нэгжийн нэр	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн овог, нэр	Үйлчилгээний төрөл	Бар, ресторан, дэлгүүрийн нэр
1	2	3	4	5	6
1	Булган сум, Жаргалант 5 дугаар баг, Д.Дамбын 1 гудамж, 118 б тоот	“Ачуутын хийморь” ХХК	М.Баасандорж	Ресторан	“Vibe”
2	Могод сум, 5-р баг Эрхэт 4 дүгээр хороо, 25-р гудамж	“Монгерус” ХХК	Д.Гүндэгмаа	Мини маркет	“Могод”
3				Кафе	“Могод”
4	Орхон сум, Мааньт 4 дүгээр баг Яргайтын модон толгой	“Оросын булаг” ХХК	Ц.Мөнхбаяр	Амралтын газрын дэргэдэх ресторан	“Наран”
5	Рашаант сум, Хар чулуут 2 дугаар баг, Их зам, 1-р гудамж-102 тоот	“Премиум нэксус” ХХК	Г.Чинзориг	Ая тухтай дэлгүүр	“CU-569” салбар
6	Хутаг-Өндөр сумын 1 дгээр баг, Магсаржав гудамж 1-128 тоот	“Түмэн сувдны хишиг” ХХК	Б.Эрдэнэсүвд	Хүнсний дэлгүүр	“Сувдан”
7	Хутаг-Өндөр сумын 1 дгээр баг, Магсаржав гудамж 3-310 тоот	“Буянтогтох өлзий” ХХК	А.Уранцэцэг	Хүнсний дэлгүүр	“Буянтогтох”
	Нийт-7				

--o00o--